

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газар УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2025/004/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.17 № 405

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ РАДИО
ТЕЛЕВИЗИЙН СҮЛЖЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Т.ГАНТУЛГА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газар” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цахим төлбөрийн баримтыг ерөнхий журнал дахь худалдан авалттай тулгахад 20.4 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлагын гүйлгээ хийсэн, Зардлын төрөл тодорхойгүй, анхан шатны дэмжих нотлох баримтгүй 1.0 сая төгрөгийн зардал гаргасан зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

011022197

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газар ТӨҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-аас 92.0 хувьтай үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>239,788,131.04</u>	<u>268,959,416.79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	225,521.04	20,002,816.79
312	Банканд байгаа бэлэн мөнгө	225,521.04	20,002,816.79
3121	Төгрөг	225,521.04	20,002,816.79
31211	Төрийн сангийн харилцах	225,521.04	20,002,816.79
35	БАРАА МАТЕРИАЛ	239,562,610.00	248,956,600.00
354	Хангамжийн материал	239,562,610.00	248,956,600.00
35410	Бичиг хэргийн материал	1,089,550.00	1,159,450.00
35420	Аж ахуйн материал	234,500.00	397,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	230,658,900.00	231,608,900.00
35470	Бусад хангамжийн материал	7,579,660.00	15,790,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,826,663,429.99</u>	<u>3,706,714,439.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,826,663,429.99	3,706,714,439.11
392	Биет хөрөнгө	822,003,333.99	702,384,391.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	647,942,448.50	647,942,448.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-107,994,417.00	-129,017,300.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,549,434.20	33,549,434.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,572,523.70	-29,034,929.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	419,681,807.90	439,481,807.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-154,926,483.54	-264,975,950.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,976,993.60	12,976,993.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,653,925.97	-8,538,112.93
393	Биет бус хөрөнгө	3,004,660,096.00	3,004,330,048.00
39301	Программ хангамж	990,144.00	990,144.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-330,048.00	-660,096.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,004,000,000.00	3,004,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,066,451,561.03</u>	<u>3,975,673,855.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>774,554.30</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	774,554.30
413	Өглөг	00.00	774,554.30
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	774,554.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,066,451,561.03</u>	<u>3,974,899,301.60</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,066,451,561.03	3,974,899,301.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,842,662,643.85	3,842,662,643.85
51101	Өмч: - төрийн	3,842,662,643.85	3,842,662,643.85
512	Хуримтлагдсан үр дүн	-607,029,260.07	-698,581,519.50
51210	Өмнөх үеийн үр дүн	-475,757,594.90	-607,029,260.07
51220	Тайлант үеийн үр дүн	-131,271,665.17	-91,552,259.43
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	830,818,177.25	830,818,177.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,066,451,561.03</u>	<u>3,975,673,855.90</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	404,239,367.77	465,497,121.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,762,100.77	171,472.68
120	Нийтлэг татварын бус орлого	2,762,100.77	171,472.68
120002	Хүүгийн орлого	16,467.77	171,472.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,745,633.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,745,633.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,477,267.00	465,325,649.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	401,477,267.00	465,325,649.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	32,799,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	501,131,367.50	557,049,381.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,131,367.50	557,049,381.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,911,700.50	526,503,524.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,557,259.59	255,807,216.22
210101	Үндсэн цалин	224,557,259.59	255,807,216.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,371,402.24	30,991,082.84
210201	Тэтгэврийн даатгал	19,424,540.24	21,768,660.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,290,821.00	2,426,949.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,810,655.00	1,792,895.41
210204	Ажилгүйдлийн даатгал	460,162.00	694,987.66
210205	Эрүүл мэндийн даатгал	4,385,224.00	4,307,589.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,885,780.36	40,519,765.55
210301	Гэрэл, цахилгаан	24,403,238.14	28,298,405.55
210302	Түлш, халаалт	9,482,542.22	12,221,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,555,650.14	22,358,143.80
210401	Бичиг хэрэг	563,100.00	1,093,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,238,664.00	12,800,473.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	561,228.38	527,209.91
210404	Ном, хэвлэл	187,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	777,777.78	924,488.89
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	6,942,972.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,227,379.98	70,000.00
2105	Нормативт зардал	308,400.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	308,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,717,604.43	13,041,530.00
210604	Урсгал засвар	23,717,604.43	13,041,530.00
2107	Томилолт, зочны зардал	3,631,600.00	1,724,160.00
210702	Дотоод албан томилолт	3,631,600.00	1,724,160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,030,146.12	22,312,634.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,786,865.32	9,641,193.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	3,150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	343,550.00	716,960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,610,784.00	7,756,984.00
210807	Газрын төлбөр	1,209,600.00	907,200.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	79,346.80	85,297.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,853,857.62	139,748,990.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	138,853,857.62	139,748,990.88
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,219,667.00	30,545,857.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,219,667.00	30,545,857.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	24,445,857.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,219,667.00	6,100,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-96,891,999.73</u>	<u>-91,552,259.43</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-96,891,999.73</u>	<u>-91,552,259.43</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>368,694,734.77</u>	<u>465,497,121.68</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,467.77	171,472.68
120	Нийтлэг татварын бус орлого	16,467.77	171,472.68
120002	Хүүгийн орлого	16,467.77	171,472.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,678,267.00	465,325,649.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	368,678,267.00	465,325,649.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	368,678,267.00	465,325,649.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>348,040,048.27</u>	<u>424,969,825.93</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,040,048.27	424,969,825.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,820,381.27	394,423,968.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,851,461.86	255,643,773.62
210101	Үндсэн цалин	227,851,461.86	255,643,773.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,670,735.56	30,991,082.24
210201	Тэтгэврийн даатгал	17,524,557.56	21,768,659.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,090,650.00	2,426,949.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,650,518.00	1,792,895.41
210204	Ажилгүйдлийн даатгал	420,128.00	694,987.66
210205	Эрүүл мэндийн даатгал	3,984,882.00	4,307,589.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,767,208.14	39,219,765.55
210301	Гэрэл, цахилгаан	24,403,238.14	28,298,405.55
210302	Түлш, халаалт	12,363,970.00	10,921,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,126,207.38	24,680,154.91
210401	Бичиг хэрэг	643,100.00	1,162,900.00
210402	Тээвэр, шатахуун	13,881,299.00	14,100,473.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	561,228.38	527,209.91
210404	Ном, хэвлэл	187,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	835,600.00

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газар ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	8,053,972.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,153,080.00	00.00
2105	Нормативт зардал	308,400.00	4,081,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	308,400.00	4,081,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,236,449.99	16,258,120.00
210604	Урсгал засвар	4,236,449.99	16,258,120.00
2107	Томилолт, зочны зардал	3,747,250.00	1,724,160.00
210702	Дотоод албан томилолт	3,747,250.00	1,724,160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,112,668.34	21,825,412.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,012,433.54	9,104,219.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	3,150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	716,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	49,752.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,811,288.00	7,756,984.00
210807	Газрын төлбөр	1,209,600.00	907,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	79,346.80	85,297.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,219,667.00	30,545,857.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,219,667.00	30,545,857.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	24,445,857.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,219,667.00	6,100,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>20,654,686.50</u>	<u>40,527,295.75</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>20,999,900.00</u>	<u>20,750,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>20,999,900.00</u>	<u>20,750,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	20,999,900.00	20,750,000.00
222001	Тоног төхөөрөмж	20,999,900.00	20,750,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-20,999,900.00</u>	<u>-20,750,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-345,213.50	19,777,295.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	570,734.53	225,521.04
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	225,521.04	20,002,816.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,842,662,643.85	830,818,177.25	-607,029,260.07	4,066,451,561.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,842,662,643.85	830,818,177.25	-607,029,260.07	4,066,451,561.03
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-91,552,259.43	-91,552,259.43
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,842,662,643.85	830,818,177.25	-698,581,519.50	3,974,899,301.60

2.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	хувь
НИЙТ ОРЛОГО	465,325,649.00	465,497,121.68	-171,472.68	100.0
I. ОРЛОГЫН ДҮН	465,325,649.00	465,497,121.68	-171,472.68	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	465,325,649.00	465,325,649.00	-	100.0
Бусад орлого	-	171,472.68	-171,472.68	-
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	465,325,649.00	445,719,825.93	19,605,823.07	95.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	413,585,000.00	394,423,968.93	19,161,031.07	95.4
Үндсэн цалин	256,200,000.00	255,643,773.62	556,226.38	99.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	32,025,000.00	30,991,082.24	1,033,917.76	96.8
Гэрэл, цахилгаан	28,320,000.00	28,298,405.55	21,594.45	99.9
Түлш, халаалт	10,920,000.00	10,921,360.00	-1,360.00	100.0
Бичиг хэрэг	960,000.00	1,162,900.00	-202,900.00	121.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540,000.00	527,209.91	12,790.09	97.6
Тээвэр, шатахуун	14,160,000.00	14,100,473.00	59,527.00	99.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000.00	835,600.00	4,400.00	99.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,400,000.00	8,053,972.00	346,028.00	95.9
Нормативд зардал	4,200,000.00	4,081,500.00	118,500.00	97.2
Эд хогшил, урсгал засвар	33,240,000.00	16,258,120.00	16,981,880.00	48.9
Дотоод албан томилолт	1,860,000.00	1,724,160.00	135,840.00	92.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,120,000.00	9,104,219.53	15,780.47	99.8
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,150,000.00	3,150,000.00	0.00	100.0
Мэдээлэл технологийн үйлчилгээ	7,800,000.00	7,756,984.00	43,016.00	99.4
Татвар	1,730,000.00	1,728,912.00	1,088.00	99.9
Банк хураамж	120,000.00	85,297.08	34,702.92	71.1
Бусад урсгал шилжүүлэг	30,740,649.00	30,545,857.00	194,792.00	99.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,640,649.00	24,445,857.00	194,792.00	99.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,100,000.00	6,100,000.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	21,000,000.00	20,750,000.00	250,000.00	98.8
Бараа үйлчилгээний бусад зардал	21,000,000.00	20,750,000.00	250,000.00	98.8

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21.4 сая төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд 1.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 20.4 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

3.1 Төлбөрийн акт

- Зардлын төрөл тодорхойгүй, анхан шатны дэмжих нотлох баримтгүй 1.0 сая төгрөгийн зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

3.2 Албан шаардлага

- Цахим төлбөрийн баримтыг ерөнхий журнал дахь худалдан авалттай тулгахад 20.4 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлагын гүйлгээ хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зардлын төрөл тодорхойгүй, анхан шатны дэмжих нотлох баримтгүй 1.0 сая төгрөгийн зардал гаргасан	1	1,044.0	1	1,044.0	-	-	-	-	-	-	-	-
Цахим төлбөрийн баримтыг ерөнхий журнал дахь худалдан авалттай тулгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлагын гүйлгээ хийсэн	1	20,416.3			1	20,416.3						
Дүн	1	21,460.3	1	1,044.0	1	20,416.3	-	-	-	-	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 3 сарын 15 өдөр

Дугаар 62/19925999

Чойбалсан хот

2025-2025/004/НА-СТН-ТӨҮГ.

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ газар ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зардлын төрөл тодорхойгүй, анхан шатны нотлох баримтгүй 1,044,000.00 төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “Анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийн данс, санхүүгийн тайлан, тооллого тооцооны бүх баримтыг төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтөлж, эмхлэн цэгцэлж, бүрэн гүйцэт бүрдэлтэйгээр архивд актаар шилжүүлэх”, 4.2.1-т “Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-т “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны нотлох баримтгүй, хэрхэн зарцуулсан тодорхойгүй 1,044,000.00 /нэг сая дөчин дөрвөн мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2125050144

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ газар ТӨҮГ-ын дарга Т.Гантулгад хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

“ХААН КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

ХТҮ-37 9030891



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 3 сарын 25 өдөр

Дугаар 06/19125199

Чойбалсан хот

00А-2025/009/НА-СТА-ТӨҮГ

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ газар ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим төлбөрийн баримтыг ерөнхий журнал дахь худалдан авалттай тулгахад 20,416,299.91 төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлагын гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040569

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Радио телевизийн сүлжээ газар ТӨҮГ-ын дарга Т.Гантулгад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:


АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

